

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ

2017 ОНЫ 5 ДУГААР САРД


2017 оны 5 дугаар сард зөвхөн Багахангай дүүргийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ) 5 саяас дээш төгрөгийн худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 100 хувь ил тод болгожээ. Шилэн дансны тухай хуулийн дагуу нийтэд ил тод болгох ёстой мэдээллүүдээс зургаан төрлийн мэдээллийг сонгон авч нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ууд хэрхэн ил тод мэдээлж байгаад иргэний нийгмийн байгууллагууд сар бүр ажиглалт хийлээ.

АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН



Өмнөх сард 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 4 дүүргийн ЗДТГ 100 хувь мэдээлж байсан бол 5 дугаар сард зөвхөн 1 дүүргийн ЗДТГ 100 хувь нийтэлсэн бууралт гарчээ.

Шилэн дансны тухай хуулийн дагуу нийслэл, дүүргүүдийн ЗДТГ 2017 оны 5 дугаар сард ил тод болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв (Тайлбар 2–ыг үзнэ үү).



НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЗДТГ-УУДЫН НИЙТЭЛСЭН ГҮЙЛГЭЭ БА ТҮҮНД ХАМААРАХ ШИЙДВЭРҮҮД



(Тайлбар 1-ийг үзнэ үү)

ХУДАЛДАН АВАЛТ БА ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Нийслэл, дүүргийн ЗДТГ-ууд 2017 оны 5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээ 6 дугаар сарын 8-ны дотор бүгд нээлттэй мэдээлжээ.
- Шилэн дансны тухай хуулийн 6.4.4-р заалтын дагуу 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг Сүхбаатар, Баянгол, Багануур, Сонгинохайрхан, Налайх, Хан-Уул дүүргүүдийн ЗДТГ-ууд нийтэлжээ.
- Хуулийн дагуу 1 дүгээр сарын 10-ны дотор нийтэд ил тод болгох ёстой тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Нийслэлийн хэмжээнд Налайх, Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ууд хугацаанд нь нийтэлсэн. Харин 2 дугаар сард Баянгол, Чингэлтэй дүүргийн ЗДТГ, 5 дугаар сард Хан-Уул дүүргийн ЗДТГ хугацаа хоцорч нийтэлсэн бол бусад дүүргийн ЗДТГ уг төлөвлөгөөг ил тод болгоогүй хэвээр байна.

Дүн мэдээнд хамаарах тайлбар:

- Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний тоог гаргахдаа шилэн дансанд ЗДТГ-ын тухайн сард нийтэлсэн нийт гүйлгээний тоог тоолж гаргасан болно.
- Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн энэ оны 5 дугаар сард хамаарах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болон гүйлгээг тооцсон болно. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий залруулга хийсэн гүйлгээг тоонд оруулсан болно.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-ын цахим хуудас

- ЗДТГ-ын мэдээллийн самбар
- Төрийн сангийн дансны хуулга

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.